

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД
ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ,
ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДОА-2025/96-ШТА-НА

Чойбалсан хот 2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
Аудитор С.Төмөрхуяг
Утас: 7058-4207, Цахим хаяг: tumurhuygs@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4-5
1. Баяндун, Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 3 нам, 8 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг хуулийн хугацаа хоцроон төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.....	6
1.1 Баяндун, Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 3 нам сонгуулийн зардлын дансны дугаар, зардлын тайлангаа хуулийн хугацаа хоцроон төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.....	6
1.2 Баяндун, Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 8 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, зардлын тайлангаа хуулийн хугацаа хоцроон төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.....	7
2. Баяндун, Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 8 нэр дэвшигч ТАБ-аас тогтоосон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.....	8
2.1 Баяндун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон “Монгол ардын нам”, “Ардчилсан нам”, “Иргэний зориг ногоон нам”-ууд ТАБ-аас тогтоосон зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.....	8
2.2 Баяндун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцож зардлын тайлангаа ирүүлсэн 8 нэр дэвшигч ТАБ-аас тогтоосон зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.....	8
ДҮГНЭЛТ:.....	8
САНАЛ.....	9
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:.....	10

Товчилсон үгийн тайлбар

НА	Нийцлийн аудит
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ШТА	Шууд тайлагнах аудит
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МАН	Монгол ардын нам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл <p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/08 дугаар тушаал, “Тушаалын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/44 дүгээр тушаал, “Гүйцэтгэлийн төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” А/82 дугаар тушаал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн гүйцэтгэсэн.</p>
Аудитын зорилт	<p>Баяндун, Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие даан нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлнэ.</p>
Аудитын хамарсан хүрээ	<p>Аудитад Баяндун, Хөлөнбуйр сумын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие дааж нэр дэвшигчдийн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамарсан.</p>
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	<p>Аудитын ажлыг гүйцэтгэхэд Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, Нийцлийн болон Санхүүгийн тайлангийн аудитын арга зүй, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны А/07 дугаартай “Дорнод аймгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох тухай” тушаалыг үндэслэн нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.</p>
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	<p>Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, аудитор М.Ухаанбилэг, аудитор С.Төмөрхуяг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн.</p> <p>Аудитыг 2025 оны 8 дугаар сарын 06-ны өдрөөс эхлүүлж, тайланг УАГ-ын Нийцлийн аудитын газарт 2025 оны 8 дугаар сарын 21-ний өдөр хүргүүлж, иргэд, олон нийтэд Төрийн аудитын байгууллагын цахим хуудсаар мэдээлж ажиллаа.</p>

Үндсэн мэдээлэл

Баяндун, Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд 3 намын 7 нэр дэвшигч, 1 бие даагч нэр дэвшсэн байна.

Хүснэгт 1

д/д	Нам, эвсэл бие даагчийн нэрс	нам	Баяндун	Хөлөнбуйр
1	Ардчилсан нам	1	2	-
2	Монгол ардын нам	1	2	1
3	Иргэний Зориг Ногоон Нам	1	2	-
4	Бие даагч	-	-	1
	дүн	3	6	2

Хөлөнбуйр сумын ИТХ-ын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 05/01 дүгээр тогтоолоор сумын 2025 оны нөхөн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан. Мөн Баяндун сумын ИТХ-ын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын сонгуулийн хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Аймгийн сонгуулийн хороонд 11, сумдын сонгуулийн хороодод 10, хэсгийн хороодод 23, мэдээлэл технологийн багт болон даамлаар 9, нийт төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний 53 албан хаагчид аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

Тус нөхөн сонгууль болсон сумдын санал хураалтад Баяндун сумын 1-р хэсэгт 858 сонгогч саналаа өгөхөөс 283 сонгогч буюу 32.9 хувийн ирцтэй, Баяндун сумын 2-р хэсэг 308 сонгогч саналаа өгөхөөс 127 сонгогч буюу 41.2 хувийн ирцтэй, Хөлөнбуйр сумын 1-р хэсэг 404 сонгогч саналаа өгөхөөс 200 сонгогч буюу 49.5 хувийн ирцтэй тус тус сонгуульд оролцсон байна.

1. Баяндун, Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 3 нам, 8 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг хуулийн хугацаа хоцроон төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

1.1 Баяндун, Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 3 нам сонгуулийн зардлын дансны дугаар, зардлын тайлангаа хуулийн хугацаа хоцроон төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.” гэж заасан.

Хүснэгт 1

д/д	Намын нэр	Дансны дугаар	Огноо
1	Ардчилсан нам	Хаан банк 5406100769	2025.08.12
2	Монгол ардын нам	Хаан банк 5606043540	2025.08.11
3	Иргэний зориг ногоон нам	Төрийн банк 260101865392	2025.08.11

Эх сурвалж: Аудиторын судалгаа

Баяндун, Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон “Монгол ардын нам”, “Ардчилсан нам”, “Иргэний зориг ногоон нам”-ууд сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг хуулийн хугацаа хоцроон төрийн аудитын байгууллагад бүртгүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж заасан.

Хүснэгт 2

д/д	Намын нэр	Зардлын тайлан, огноо
1	Ардчилсан нам	2025.08.12
2	Монгол ардын нам	2025.08.11
3	Иргэний зориг ногоон нам	2025.08.11

Эх сурвалж: Аудиторын судалгаа

Дорнод аймгийн “Монгол ардын нам”, “Ардчилсан нам”, “Иргэний зориг ногоон нам” нь сонгуулийн зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан хуульд заасан хугацааг хоцроон төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 3 намын зардлын тайланг хянаж үзэхэд мөнгөн болон мөнгөн бус хандив аваагүй байна.

1.2 Баяндун, Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 8 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, зардлын тайлангаа хуулийн хугацаа хоцроон төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.”, 56 дугаар зүйлийн 56.3 “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж тус тус заасан.

Хүснэгт 3

№	Нам, сумын нэр	Нэр дэвшигч	Дансны дугаар	Зардлын тайлан ирүүлсэн огноо
1	Монгол Ардын нам /Баяндун/	Б.Болдмаа	Төрийн банк 260101865375	2025.08.11
2	Ардчилсан нам /Баяндун/	Б.Доржням	Төрийн банк 260101864649	2025.08.04
3	Ардчилсан нам /Баяндун/	Г.Баттөмөр	Төрийн банк 260100031391	2025.08.04
4	Монгол Ардын нам /Баяндун/	Н.Болд-Эрдэнэ	Төрийн банк 260101865381	2025.08.11
5	Иргэний Зориг ногоон нам /Баяндун/	Н.Энхтайван	Төрийн банк 260101865392	2025.08.11
6	Иргэний Зориг ногоон нам /Баяндун/	А.Батгэрэл	Голомт банк 4715123572	2025.08.11
7	Монгол Ардын нам /Хөлөнбуйр/	А.Батмөнх	Төрийн банк 261001866753	2025.08.04
8	Бие даагч /Хөлөнбуйр/	Ж.Мөнгөндуулга	Төрийн банк 261001861313	2025.08.11

Эх сурвалж: Аудиторын судалгаа

Баяндун, Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 8 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, зардлын тайлангаа хуулийн хугацаа хоцроон төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 8 нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж үзэхэд мөнгөн болон мөнгөн бус хандив аваагүй байна.

2. Баяндун, Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 8 нэр дэвшигч ТАБ-аас тогтоосон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.

2.1 Баяндун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон “Монгол ардын нам”, “Ардчилсан нам”, “Иргэний зориг ногоон нам”-ууд ТАБ-аас тогтоосон зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.

Баяндун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон “Монгол ардын нам”, “Ардчилсан нам”, “Иргэний зориг ногоон нам”-ууд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/07 дугаар тушаалаар баталсан зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.

2.2 Баяндун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцож зардлын тайлангаа ирүүлсэн 8 нэр дэвшигч ТАБ-аас тогтоосон зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.

Баяндун, Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 8 нэр дэвшигчээс сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн 8 нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж үзэхэд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/07 дугаар тушаалаар баталсан зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1.1 Баяндун, Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 3 нам сонгуулийн зардлын дансны дугаар, зардлын тайлангаа хуулийн хугацаа хоцроон төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

1.2 Баяндун, Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 8 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, зардлын тайлангаа хуулийн хугацаа хоцроон төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

2.1 Баяндун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон “Монгол ардын нам”, “Ардчилсан нам”, “Иргэний зориг ногоон нам”-ууд ТАБ-аас тогтоосон зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.

2.2 Баяндун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцож зардлын тайлангаа ирүүлсэн 8 нэр дэвшигч ТАБ-аас тогтоосон зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.

САНАЛ: Үндэсний аудитын газарт

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. Нам, нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, зардлын тайлангаа хуульд заасан хугацааг хоцроон төрийн аудитын байгууллагад ирүүлсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар хууль, тогтоомжид тодорхой заагаагүй байна. Иймд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд тодорхой зохицуулалт оруулж өгөх.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/26

Чойбалсан хот

Г Тайлан баталгаажуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяад хүргүүлсүгэй.

3. Аудитын тайланг Төрийн аудитын байгууллагын цахим хуудсанд байршуулж, иргэд, олон нийтэд мэдээлж ажиллахыг мэдээлэл, технологи хариуцсан аудитор М.Ухаанбилэгт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2125010049

ДОРНОД АЙМАГ, ХЭРЛЭН СУМ, 7-Р БАГ АЙМГИЙН ЗДТГ-ЫН БАЙР
УТАС: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-МЭЙЛ: DORNOD@AUDIT.GOV.MN , ВЕБ САЙТ: WWW.AUDIT.MN